



Галшарын улаан ямааны ашиг шимийн зарим үзүүлэлтүүд

Д.Батсүрэн, Б.Нарантуяа *

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, ХААИС, Улаанбаатар, Монгол Улс

*Холбоо барих хаяг: nango2010@gmail.com

ХУРААНГУЙ

Хэнтий аймгийн Галшар суманд үржүүлж буй нутгийн ямаа 2017 онд 119.3 мянган толгойд хүрсэн бөгөөд жилд дунджаар 8.9 хувиар өсчээ. Галшарын улаан ямааны бүдүүн ухны хаврын амьдын жин 48.5, борлон ухна 28.07, эм ямаа 37.7, охин борлон 21.7 кг ба хаврын жингээ намарт бүдүүн ухна 29.3%, борлон ухна 30.7%, бүдүүн эм ямаа 20.4 %, охин борлон 47.5% нэмэгдүүлдэг. Бүдүүн ухны ноолуурын гарц 585.4 г, голч 16.42 мкм, урт 4.54 см, дээрхи дараалаар борлон ухных 438.5; 15.84; 3.99; эм ямааных 492.2; 16.33; 4.52; охин борлонгийнх 411.4; 15.66; 3.86; байв. Галшарын улаан ямааны нядлагын гарц эр ямаанд 52.6%, эм ямаанд 52.3%, сүүний гарц төллөх үед 154.6 г, саалийн ид оргил үед 256.9 г сүү өгдөг ба саалийн хугацааны дунджаар 13.9-17.4 сүү ашигладаг.

ТҮЛХҮҮР ҮГ: Галшар, ямаа, ноолуур, сүү, сааль

ОРШИЛ

Монголчууд урт хугацааны туршид ямааг үржүүлж, түүний сүү, мах, ноолуур, хялгас зэрэг бүтээгдэхүүнийг амьдрал ахуйдаа ашиглаж ирсэн түүхтэй. Монгол Улс 2017 онд түүхэндээ хамгийн олон 66.2 сая тооны мал тоолуулсны дотор 27.3 сая ямаа тоолуусан [13]. Дэлхийн ноолуурын нөөцийн 67%-ийг Хятад, 31%-ийг Монгол улс бүрдүүлдэг. Малын генетик нөөцийн тухай хуулийг 2018 онд батлагдсан бөгөөд “Монгол Улсын малын генетик нөөцийг бүртгэх, төлөв байдлыг тодорхойлох, хадгалах, хамгаалах, тогтвортой ашиглах, судлан хөгжүүлэхтэй

холбогдсон харилцааг зохицуулахаар заасан [8]. Мөн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хоёрдугаар тэргүүлэх чиглэлийн 3.21.3-д Монгол малын ашиг шимийн түвшинг бүсчилэн тогтоож, биологийн нөөц боломжийг илрүүлж, үржил селекцийн ажлыг зорилгод зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн явуулахаар тусгасан байдаг [9]. Энэхүү бодлого хөтөлбөрийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар суманд үржүүлж буй улаан ямааны ашиг шимийн зарим үзүүлэлт судлан тогтоолоо.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

Тал хээр, хуурай хээрийн бүсэд орших Галшар сумын Оч, Сангийндалай, Баянбадрал, Арвин, Жаргалант багуудын 45 өрхийн 11900 ямаанд хавар, намрын амьдын жин, биеийн үндсэн хэмжилт хийж, янз бүрийн нас, хүйсний 322 ямааны ноолуурын гарцыг хяналтын самналтаар, мөн тооны ямаанаас ноолуурын дээжийг авч ширхэгтийн


эзлэх хувь, урт, голч зэрэг үзүүлэлтийг МААЭШХ-ийн “Ноолуур судлал” -ын лабораторид, 6 ямаа нядлаж махны гарц, чанарын үзүүлэлтүүдийг САМО хүнсний эрдэм шинжилгээний хүрээлэнд, 35 ямаанд хяналтын саалт хийж сүүний гарцыг тус тус тодорхойлов.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Хэнтий аймгийн Галшар суманд үржүүлж буй нутгийн улаан ямаанд 1973 онд ахмад малзүйч А.Хишигт үзлэг хийхэд нас гүйцсэн ухна 51.2 кг, борлон ухна 33 кг, эм ямаа 40 кг амьдын жинтэй байсан ба улаан ямаа бусад зүсний ямааг бодвол биеэр харьцангуй том, хээл хаялт, сувайралт бага, тэсвэр хатуужилтай гэж үзэн цаашид улаан зүсмийн ямааг сонгон үржүүлвэл зүйтэй гэж үзэн ангилалт, заазлалтыг жил бүр хийж улмаар тухайн ямаа 1983 оны байдлаар нас гүйцсэн ухны амьдын жин 59 кг, борлон ухны жин 37.5 кг, эм ямаа 48 кг болж амьдын жин 4.5-8 кг-аар нэмэгдсэн байсныг хавар намрын ангилалтаар тогтоожээ. Сум нэгдлийн дарга Н.Дэрийлаа 1989 онд энэхүү улаан ямааны үржлийн ферм байгуулах саналыг Хэнтий аймгийн Ардын Депататуудын хуралд тавьж тухайн 9-р сард шийдвэрийг гарган ямааны фермийг Оч бригадад 500 толгой шилмэл ямаа бүхий 10 суурь (5000 ямаатай) бий болгосон байна. Зах зээлд шилжэхэд (1991

онд) нэгдлийн дарга Н.Дэрийлаа хоршоо байгуулан улаан ямааг 2007 он хүртэл үржүүлж байсан байна. Хэнтий аймгийн Галшар сумын Засаг Даргын Тамгын газар болон Хэнтий аймгийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн Газраас 2015 онд МААЭШХ-д Галшарын улаан ямаанд судалгаа хийлгэх хүсэлтийг тавьснаар тухайн сумын ямаан сүрэгт 2015-2018 онуудад энэхүү судалгааг явуулж дараах үр дүнг гаргасан.

Галшарын улаан ямааны тоо толгой тархалт. Тус ямааг Хэнтий аймгийн Галшар, Баянхутаг, Баянмөнх, Дархан сумдад голлон үржүүлдэг боловч Хэнтий аймгийн нийт сумдад жигд тархсан. Мал тооллогын 2016 оны дүнгээр Галшар сум 295895 мал тоолуулсны дотор 119410 ямаатай байна. Ноолуурын чиглэлийн Галшарын улаан ямааг голлон үржүүлж буй дээрх сумдын ямааны сүрэгт эзлэх хээлтэгчийн хувийн жин 44-46 хувьтай, сүргийн өсөлт 6.7-11.0 хувьтай байна.



1-р зураг. Галшар сумын ямаан сүргийн тоо толгойн өсөлт / мян тол/ хувь/2013-2017 он/

Сүүлийн 5 жилийн байдлаар ямааны тоо толгой жилд дунджаар 8.9 хувиар, 2016 онд 0.5 хувийн өссөн ба 2016 оныг 2013 оныхтой харьцуулахад ямааны тоо толгой 22.6 %-иар өсчээ. Бэлчээрийн хүрэлцээ хангамжаас шалтгаалан малчид ямааг жил өнжөөх, өсвөр насны ямааг хээлтүүлэгт оруулахаас зайлсхийх болсон байна.

Галшарын улаан ямааны амьдын жин, биеийн үндсэн хэмжээ. Ямааны амьдын жин болон биеийн үндсэн хэмжээг тодорхойлохын тулд цөм болон үржлийн

сүргийн 10800 толгойг төлөөлүүлэн 3600 ямаанд намар, хаврын жигнэлт, хэмжилт хийв. Нийт хэмжилт хийсэн малын 15.7 хувийг хээлтүүлэгч, 51.1 хувийг эм ямаа, 33.2 хувийг өсвөр насны ямаа эзэлж байна. Галшар сумын нутгийн ямааны амьдын жин дунджаар хавар: бүдүүн ухна 48.5 кг, борлон ухна 28.07 кг, бүдүүн эм ямаа 37.7 кг, охин борлон 21.7 кг, намар: бүдүүн ухна 62.7 кг, борлон ухна 36.7 кг, бүдүүн эм ямаа 45.4 кг, охин борлон 32.0 кг байна.

Хүснэгт 1

Нас, хүйс	Галшарын улаан ямааны амьдын жингийн үзүүлэлт					
	Хаврын амьдын жин, кг			Намрын амьдын жин, кг		
	M±m	Cv	Хэлбэлзэл	M±m	Cv	Хэлбэлзэл
Бүдүүн ухна	48.5±1.16	18.1	33.9-66.6	62.7±1.42	15.98	48.1-91.3
Бүдүүн эм ямаа	37.7±0.39	18.76	23.7-54.8	45.4±0.34	13.87	35.2-78.0
Борлон ухна	28.1±0.89	17.97	21.9-41.6	36.7±1.66	16.29	29.6-45.0
Охин борлон	21.7±0.44	16.91	16.1-29.5	32.0±0.58	9.85	28.6-38.0

Үржлийн ямааны хаврын амьдын жин хэлбэлзэл ихтэй (Cv 16.9 %-иас дээш), үржлийн ухна намар дээд тал нь 91.3 кг, эм ямаа 78.0 кг жинд хүрч

байгаа нь цаашид биерхэг чанараар өөр дотор нь шилэн сонгож үржүүлэх боломж байгааг харуулж байна.

Хүснэгт 2

Үзүүлэлт	Ямааны амьдын жингийн нэмэгдэл					
	Хэмжилт хийсэн малын тоо		Амьдын жин, кг		Жингийн нэмэгдэл	
	Хавар	Намар	Хавар	Намар	кг	%
Бүдүүн ухна	268	117	48.5±1.16	62.7±1.23	14.2	29.28
Борлон ухна	90	90	28.07±0.89	36.7±1.66	8.63	30.74
Эм ямаа	958	882	37.7±0.39	45.4±0.34	7.7	20.42
Охин борлон	598	597	21.7±0.44	32.0±0.58	10.3	47.47

Бүдүүн ухна хаврын жингээ намар 29.3%, борлон ухна 30.7%, бүдүүн эм ямаа 20.4%, охин борлон 47.5% нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 3

Үзүүлэлт	Үржлийн ямааны биеийн үндсэн хэмжээ								
	Хэмжилт хийсэн малын тоо		Биеийн хэмжээ, см /намар/						
	Хавар	Намар	СӨ ¹	ХӨ ²	БТУ ³	ЦГ ⁴	ЦӨ ⁵	ЦБ ⁶	ШБ ⁷
Бүдүүн ухна	268	117	66.9	67.7	75.0	34.1	22.3	88.9	9.2
Борлон ухна	90	90	57.4	58.0	63.9	28.4	20.0	72.9	7.9
Эм ямаа	958	882	62.8	63	69.1	30.1	18.4	82.1	8.3
Охин борлон	598	597	58.9	59.2	60.9	26.1	16.2	71.3	7.5

¹Сэрвээний өндөр, ²Хондлойн өндөр, ³Биеийн ташуу урт, ⁴Цээжний гүн, ⁵Цээжний өргөн, ⁶Цээжний бүслүүр, ⁷Шилбэний бүслүүр

Галшарын улаан ямааны нас гүйцсэн ухны лагс чамбайн заалт 118.5, борлон ухна 114.1, эм ямаа 118.8, охин борлон 117.1см, биеийн урт нас хүйснээс хамаарч 103.4- 112.1см, ясархагын заалт 12.7-13.6 см тус тус байна.

Галшарын улаан ямааны ноолуурын гарц чанарын үзүүлэлт. Галшарын улаан ямааны үндсэн ашиг шим нь ноолуур бөгөөд улаан хялгастай улаан туяатай цагаан цайвар өнгийн ноолуур өгдөг. Ноолуурын гарц ба чанарын үзүүлэлтийг 322 ямаанаас авсан дээжинд тодорхойлов.

Хүснэгт 4

Нас, хүйс	Ноолуурын гарц (г)	Ямааны ноолуурын гарц, чанар			
		Нийт үсэнд ширхэгтийн эзлэх хувь(%)		Ноолуурын	
		Ноолуур	Хялгас	Голч(мкм)	Урт(см)
Бүдүүн ухна	585.4 ±3.64	80.28±0.29	36.00±0.98	16.42±0.01	4.54±0.02
Борлон ухна	438.5±2.95	82.6±0.23	28.31±0.97	15.84±0.02	3.99±0.02
Бүдүүн эм ямаа	492.2±2.33	87.5±0.2	23.65±0.32	16.33±0.01	4.52±0.01
Охин борлон	411.4±2.7	89.0±0.21	21.95±0.54	15.66±0.02	3.86±0.01

Галшарын улаан ямааны ноолуурын гарц бүдүүн ухных 585.4 г, ноолуурын голч 16.42 мкм, ноолуурын урт 4.54 см, борлон ухных 438.5 г, ноолуурын голч 15.84 мкм, ноолуурын урт 3.99 см, бүдүүн эм ямааны ноолуурын гарц 492.2 г, голч 16.33 мкм, ноолуурын урт 4.52 см, охин борлонгийн ноолуурын гарц 411.4 г, ноолуурын голч 15.66 мкм, ноолуурын урт 3.86 см байна. Нийт үсэнд ноолуурын эзлэх хувийн жин 80.28-89.0 хувь байна.


Галшарын улаан ямааны махан ашиг шим. Махан ашиг шимийг эр ямаа 3, эм ямаа 3 нийт 6 ямаанд тодорхойлоход сойлтын дараах жин дунджаар эр ямаанд 63.7 кг, эм ямаанд 30.0 кг, гулуузны жин эр ямаанд 28.1 кг, эм ямаанд 19.2 кг, дотор өөхний жин эр ямаанд 5326 г, эм ямаанд 4342 г, нядлагын жин эр ямаанд 33.4 кг, эм ямаанд 23.5 кг, нядлагын гарц эр ямаанд 52.6 %, эм ямаанд 52.3 % байна.

Хүснэгт 5

№	Үзүүлэлт	Махан ашиг шимийн үзүүлэлт					
		Эр ямаа				Эм ямаа	
		Улаан	Улаан	Улаан	Улаан	Улаан	Улаан
1	Зүс						
2	Хувийн дугаар	001	003	004	002	005	006
3	Сойлтын өмнөх жин, кг	64.0	81.0	62.4	47.5	52.2	48.4
4	Сойлтын дараах жин, кг	57.7	72.3	61.2	45.2	50.2	39.6
5	Дөрвөн шийрний жин, гр	1050	1300	1135	780	855	630
6	Толгой, эрүүний жин, гр	2130	2300	2180	1685	1705	1710
7	Дотор өөхний жин, гр	5365	6565	4050	3450	4850	4725
8	Зүрх, гр	195	270	230	205	222	183
9	Уушиг, гр	395	470	330	296	243	224
10	Элэг, гр	945	1025	1040	800	910	920
11	Дэлүү, гр	75	95	95	60	92	60
12	Бөөр, гр	155	170	190	151	184	155
13	Цөс, гр	40	48	20	53	45	33
14	Өрц, гр	300	310	100	168	167	97
15	Улаан хоолой, гр	95	90	85	55	95	35
16	Цагаан /мөгөөрсөн/ гр	90	110	95	110	145	45
17	Цус, гр	1815	2425	2220	1500	2050	1490
18	Нойтон гулуузны жин, кг	26.4	31.0	27.0	19.3	21.3	16.9
19	Загссан гулуузны жин, кг	26.1	30.6	26.6	19.0	21.0	26.7
20	Тал гулуузны жин, кг	13.1	15.5	13.2	8.7	10.7	8.3
21	Өөх, гр	3440	2005	1980	1025	2060	1215
22	Мах, кг	7.44	8.03	7.8	5.5	5.8	4.8
23	Яс, гр	1960	1885	2270	2260	1390	1355
24	Бүлх, хальс, гр	1250	630	730	310	270	410
25	Булчирхай, гр	80	95	85	90	110	145
26	Нойтон арьсны жин, гр	4055	4600	3675	3225	3805	2625
27	Арьсны урт, см	125.6	130	130.9	110	123	115.2
28	Арьсны өргөн, см	97	104.3	104.2	82.5	93.5	88
29	Арьсны талбай, дм ²	121.3	135.6	136.4	90.8	115.0	101.4
30	Нядлагын гарц, %	55.05	51.96	50.74	50.33	52.09	54.61
			52.6			52.3	

Галшарын улаан ямааны сүүн ашиг шим. Говь, тал хээрийн бүсэд малчдын сүүний хэрэгцээг ямааны сүүгээр хангадаг хэдий ч зүүн бүс нутагт ямааны сүүг төдийлөн

ашиглаад байдаггүй. Галшар сумын малчид ямааг 06 дугаар сарын дунд үеэс 08 дугаар сарын эх хүртэл өөрсдийн хэрэгцээндээ сааж, сүү саалийг ашигладаг.



2-р зураг. Сүүний гарц /гр/

Хяналтын саамаар төллөх үе буюу 4-р сард хугацааны дундаж саам 13.9-17.4 сүү бэлтгэдэг дунджаар 1 ямаанаас 154.6г, саалийн ид оргил байна. үе буюу 7-р сард 256.9 г сүү гардаг ба саалийн

ШҮҮН ХЭЛЭЛЦЭХҮЙ

Галшарын улаан ямааны амьдын жинг Монгол орны баруун бүсэд үржүүлж буй Бөмбөгөрийн улаан, Өлгийн улаан омгийн ямаатай харьцуулахад 1.65-9.81 % илүү [3], үржлийн ухнын амьдын жин Монгол болон Алтайн улаан үүлдрийнхээс 7.9-10.6 % илүү [4], харин зүүн бүсэд үржүүлж буй Баяндэлгэр үүлдрийн ямаатай харьцуулахад 6.0-18.2 % доогуур байна. Галшарын улаан ямааны ноолуурын гарц сүргийн дунджаар 481.9г байгаа нь Б.Нарантуяа (2010)-гийнхтай харьцуулахад 91.1 г буюу 23.3%, ухна 84.7г буюу 16.9%, эм ямаа 77.8г буюу 18.4%-иар тус тус илүү байна [12]. Галшарын улаан ямааны ноолуурын дундаж голч сүргийн дунджаар

16.06 мкм Ё.Загдсүрэн, Б.Мандах, Н.Надмид (1993, 1995) нарынхаас 1.5-2.1 мкм-ээр [6,7,10], Б.Нарантуяа, Д.Батсүрэн (2015) гийнхээс 0.5мкм-ээр тус тус бүдүүссэн байна [11]. Галшарын улаан ямааны сойлтын дараах жин эр ямаанд 63.7 кг, эм ямаанд 45.0 кг, нядлагын гарц эр ямаанд 52.6%, эм ямаанд 52.3%, гулуузны жин эр ямаанд 27.8 кг, эм ямаанд 22.2 кг, дотор өөхний жин эр ямаанд 5.3 кг, эм ямаанд 4.3 кг байгаа нь монгол үүлдрийн ямаатай /Р.Дашдэлэг, Д.Банзрагч, 1989/ харьцуулахад [5] сойлтын дараах жин 14.8 кг-аар, гулуузны жин 6.2 кг-аар, дотор өөхний жин 1.3 кг-аар, нядлагын жин 7.5 кг, нядлагын гарц 0.4 %-иар тус тус илүү байна.

ДҮГНЭЛТ

1. Галшарын улаан ямааны тоо 2017 оны жилийн эцсийн байдлаар 119.3 мянган толгой, цөм сүргийн тоо 23.3 мянга байгаа бөгөөд жилд дунджаар 8.9 хувиар, 2013 онтой харьцуулахад ямааны тоо толгой 22.6 %-иар өсчээ.
2. Галшарын улаан ямааны бүдүүн ухнаны хаврын амьд жин 48.5, борлон ухна 28.07, эм ямаа 37.7, охин борлон 21.7 кг намрынх дээрх дарааллаар 62.7, 36.7, 45.4, 32.0кг тус байна. Бүдүүн ухна хаврын жингээ намарт 29.3%, борлон ухна 30.7%, бүдүүн эм ямаа 20.4 %, охин борлон 47.5% нэмэгдүүлж байна.
3. Галшарын улаан ямааны нас гүйцсэн ухны лагс чамбайн заалт 118.5, борлон ухна 114.1, эм ямаа 118.8, охин борлон 117.1см, биеийн урт нас хүйснээс хамаарч 103.4-112.1см, ясархагын заалт 12.7-13.6 см тус тус байна.
4. Галшарын улаан ямааны ноолуурын гарц **бүдүүн ухных** 585.4 г, ноолуурын голч 16.42 мкм, ноолуурын урт 4.54 см, **борлон ухных** 438.5 г, ноолуурын голч 15.84 мкм, ноолуурын урт 3.99 см, **бүдүүн эм ямааны** ноолуурын гарц 492.2 г, голч 16.33 мкм, ноолуурын урт 4.52 см, **охин борлонгийн** ноолуурын гарц 411.4 г, ноолуурын голч 15.66 мкм, ноолуурын урт 3.86 см байна. Нийт үсэнд ноолуурын эзлэх хувийн жин 80.3-89.0 хувь байгаа нь уг ямааны үндсэн ашиг шим нь ноолуур болохыг илтгэж байна.
5. Галшарын улаан ямааны нядлагын гарц эр ямаанд 52.6%, эм ямаанд 52.3%, гулуузны

жин эр ямаанд 27.8 кг, эм ямаанд 22.2 кг, дотор өөхний жин эр ямаанд 5.3 кг, эм ямаанд 4.3 кг байгаа нь монгол үүлдрийн ямаа 0.4 %-иар илүү үзүүлэлттэй байна.

Галшарын улаан ямааны сүүний гарц төллөх үед 154.6 г, саалийн ид оргил үед 256.9 г сүү өгдөг ба саалийн хугацааны дунджаар 13.9-17.4 сүү бэлтгэдэг байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

- [1]“Баяндэлгэрийн улаан” ямааны үүлдрийн тодорхойлолт, УБ, 2015, х-24
- [2]Баярмаа.Н., Нарантуяа., Б. “Галшарын улаан ямааны ноолуурын чанарын зарим үзүүлэлт” ХААШУА-ын сэтгүүл УБ, 2017, х 3-6
- [3]“Бөмбөгөрийн улаан” ямааны омгийн тодорхойлолт, УБ, 2015, х-46
- [4]“Алтайн улаан” ямааны үүлдрийн тодорхойлолт, УБ, 2016, х-51
- [5]Монгол үүлдрийн ямааны тодорхойлолт, УБ, 1991, х-32
- [6]Мандах Б. Болор-Эрдэнэ Г. Монгол ямааны биеийн хэсгүүдийн ноолуурын нарийн. (1994) 28, 39-42 УБ.
- [7]Мандах Б., Янз бүрийн хэвшлийн монгол ямааны ашиг шим. МААЭШХ-гийн бүтээл, (1994), 27, 9-15
- [8]Малын генетик нөөцийн тухай хууль, УБ, 2018
- [9]“Монгол мал” үндэсний хөтөлбөр, УБ, 2010
- [10]Надмид Н. Нутгийн монгол ямааны ашиг шимийн зарим үзүүлэлтүүд. ХААИС-ийн э/ш бүтээл. (1993) 27:37-42 УБ.
- [11]Нарантуяа.Б Батсүрэн.Д. Хэнтий аймгийн зарим сумдын ямааны ноолуурын чанарын үзүүлэлт. Хүрэл тогоот-2015 Биологи-Хөдөө Аж Ахуйн салбар УБ. (2015) х.163-167
- [12]Narantuya.B (Ph.D)., D.Tseveenamjil (Ms.D) ‘Four factor analysis of variance of fiber diameter’, ХААШУСэтгүүл англи хэлээр УБ, 2015, х 29-37
- [13]1212.mn
- [14]Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого,

Some indicators of productivity of galshar red goat

Batsuren D., Narantuya B.*

Research Institute of Animal Husbandry, Mongolian University of Life Sciences, Ulaanbaatar, Mongolia

* Corresponding author: nango2010@gmail.com

ABSTRACT

The indigenous has reached 119.3 thousand heads in 2017 in Khentii province Galshar sum, an increase of 8.9 percent annually. The live weight of the spring for red goats of Galshar was the adult buck averages 48.5kg, young buck 28.07kg, adult doe 37.7kg, young doe 21.7kg, and spring weight is being increased until autumn, such as adult buck 29.3%, young buck 30.7%, adult doe 20.4%, young doe 47.7%. Cashmere yield of adult buck averages at 585.4g, 16.42mkm diameter, 4.54cm length, in the above sequence young buck 438.5; 15.84; 3.99; adult doe 492.2; 16.33; 4.52; young doe 411.4; 15.66; 3.86; Galshar red goat in slaughter rate is castrated adult male 52.6%, adult doe 52.3%, dairy milk yield the period of calving 154.6g, and 256.9 g of milk during peak dairy production and 13.9-17.4 milk of average lactation period.

KEY WORDS: Cashmere, milk, dairy milk